



2025 ЭРГЭН МЭДЭЭЛЭЛ

www.gemtel.mn

Хянасан:

Б. Түмэн-Өлзий /СТСАлбаны дарга,
Мэдээлэл зүйн мэргэжилтэн/

Тайлан боловсруулсан:

СТСАлбаны:
Х. Мөнхзул /Эпидемиологич/
А. Анхтуяа /НЭМ-ийн мэргэжилтэн/

ГАРЧИГ

- Үзүүлэлт тооцсон аргачлал

БҮЛЭГ 1

- 2025 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн байдалд хийсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 2

- 2025 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын байдалд хийсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 3

- Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын тандалтын мэдээ, тайлангийн үнэлгээ
- Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын бүртгэл, цахим мэдээний сан, сарын мэдээ, жилийн эцсийн тайлантай холбоотой анхаарах зүйлс, нийтлэг гарч буй хүндрэл, алдааны тухай

ҮЗҮҮЛЭЛТ ТООЦСОН АРГАЧЛАЛ

1. Осол гэмтлийн өвчлөлийн тохиолдлын түвшинг (ТТ) тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шинэ тохиолдлын тоог тухайн жилийн суурин дундаж хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
2. Осол гэмтлийн тархалтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд осол гэмтлийн шалтгаанаар эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан нийт тохиолдлын тоог тухайн жилийн суурин дундаж хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
3. Осол гэмтлийн шалтгаан тус бүрийн өвчлөлийн түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн (ӨОУА-10 дагуу осол гэмтлийн шалтгаан тус бүрээр) осол гэмтлийн шинэ өвчлөлийн тоог тухайн жилийн суурин дундаж хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
4. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдлын тоог тухайн жилийн суурин дундаж хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
5. Осол гэмтлийн үхлийн түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдлын тоог тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн өвчлөлийн тоонд харьцуулан, 1 000 гэмтэл тутамд тооцсон.
6. Осол гэмтлийн шалтгаан бүрт нас баралтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд тухайн шалтгаанаар бүртгэгдсэн нас баралтыг тухайн жилийн суурин дундаж хүн амд харьцуулан, 10 000 хүн амд тооцсон.
7. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын болон өвчлөлийн тархалтыг харуулахдаа тухайн аймаг, дүүрэгт бүртгэгдсэн тохиолдлыг тухайн аймаг дүүргийн суурин дундаж хүн амд харьцуулан, 10 000 хүн амд тооцсон.



I БҮЛЭГ

2025 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн
байдалд хийсэн дүн шинжилгээ

МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛИЙН БАЙДАЛ 2025 ОН

1. ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ

Монгол улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар осол гэмтлийн шалтгаант өвчлөл 2021-2025 он хүртэл 1.6 дахин өссөн байна. 2025 онд өмнөх оноос 4.4 хувиар өссөн бөгөөд 10 000 хүн амд ногдох тохиолдлын түвшин 679.4 байна. 2021-2025 онд ослын түвшин шугаман өсөх хандлагтай байгааг харуулж байна.

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, 10 000 хүн амд, оноор



Жич: 2025 оны хүн амын жилийн эцсийн үзүүлэлт биш болно. Тухайн үзүүлэлт 2025 оны 4 сард гарах ба одоогийн үзүүлэлтийг 2024 оны хүн амаар тооцов./

59.8% 10 000 хүн амд 824.3



Нийт тохиолдлын 138959 (59.8%) эрэгтэй, 93356 (40.2%) эмэгтэй байна. Өөрөөр хэлбэл осол гэмтлийн шалтгаант 10 шинэ тохиолдол тутмын 6 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй байна.

40.2% 10 000 хүн амд 538.6



2025 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн тохиолдол 10-14 насанд 27317 (11.8%) хамгийн өндөр байна.

Осол гэмтлийн өвчлөл насны бүлгээр, 2025 он



Насны бүлэг, хүйсээр 10 000 хүн амд ногдох тохиолдлын түвшинг харьцуулан харахад эрэгтэй

дундаж түвшин 799.6, эмэгтэй дундаж түвшин 560.7 байна. Эрэгтэйд 15-19 насанд түвшин хамгийн өндөр байсан ба 10-39 насанд дунджаас өндөр байв. Харин эмэгтэйд 65-с дээш насанд тохиолдлын түвшин ихэсч дунджаас өндөр үзүүлэлттэй байна.

Насны бүлэг, хүйс, тохиолдлын түвшнээр



2025 онд санаатай (хүчирхийлэл, амиа хорлох) осол гэмтэлд 21369 тохиолдол (9.2%), санамсаргүй осол гэмтэлд 210946 тохиолдол (90.8%) өртсөн байна. Энэ нь осол гэмтлийн дийлэнх хувийг санамсаргүй шалтгаант тохиолдол бүрдүүлж байгаа боловч ойролцоогоор 100 хүн тутмын 9 нь санаатай үйлдлээс үүдсэн гэмтэлд өртөж байгааг харуулж байна. Иймд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх бодлого нь нэг талаас ахуйн болон орчны эрсдэлийг бууруулах (санамсаргүй осол), нөгөө талаас хүчирхийлэл, амиа хорлох зэрэг санаатай үйлдлээс урьдчилан сэргийлэх сэтгэл зүй, нийгмийн хамгааллын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.



Санамсаргүй осол



Санаатай осол



Осол гэмтлийн өвчлөлийг шалтгаанаар харахад уналтын шалтгаан 1-рт 93251 (40.1%), амьгүй механик хүчинд өртөх 2-рт 45490 (19.6%), зам тээврийн осол 3-рт 30888 (13.3%), амьтай механик хүчинд өртөх 4-рт 20595 (8.9%), хүчирхийлэл 19657 (8.5%) 5-рт байна. Үр дүнгээс харахад эхний хоёр шалтгаан (уналт болон амьгүй механик хүчин) нийт тохиолдлын 59.7%-ийг бүрдүүлж байгаа нь осол гэмтлийн өвчлөлийн бүтэц тодорхой шалтгаанд төвлөрч байгааг харуулж байна.

Осол гэмтлийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, 2025 он



2021–2025 оны хугацаанд ихэнх осол гэмтлийн шалтгаанууд өсөх чиг хандлагатай байна. Ялангуяа зам тээврийн осол, амьгүй механик хүчинд өртөх, амьтай механик хүчинд өртөх, түлэгдэлт, хордолт, амьсгал боогдох шалтгаанууд тогтвортой нэмэгдэж байгаа нь нийгмийн болон орчны эрсдэлт хүчин зүйлс нэмэгдэж байгааг харуулж байна.

Осол гэмтлийн шалтгаан	ӨОУА-10	Тохиолдлын тоо					Нийт	%	↕
		2021	2022	2023	2024	2025			
Санамсаргүй осол гэмтэл									
Уналт	W00-W19	59839	84602	94550	94523	93251	426765	42.8	
Амьгүй механик хүчинд өртөх	W20-W49	24963	30386	34000	40781	45490	175620	17.6	
Зам тээврийн осол	V01-V99	15957	21128	23548	27660	30888	119181	12.0	
Амьтай механик хүчинд өртөх	W50-W64	10945	15455	17675	19215	20595	83885	8.4	
Түлэгдэлт	W85-X19	5637	6333	004	7091	7627	33692	3.4	
Тодорхойгүй осол	Y10-Y34	5051	6455	7301	5901	4676	29384	2.9	
Санамсаргүй хордох	X40-X49	2845	3109	3857	4314	4779	18904	1.9	
Бусад осол	X50-X59	1002	1310	1446	1579	2196	7533	0.8	
Байгалийн хүчинд өртөх	X30-X39	701	999	1132	850	811	4493	0.5	
Амьсгал боогдох	W75-W84	192	236	245	216	285	1174	0.1	
Усанд живэх	W65-W74	147	112	106	134	103	602	0.1	
Хорт амьтан ургамалд өртөх	X20-X29	112	115	180	70	245	722	0.1	
Санаатай үйлдлээс үүдсэн осол гэмтэл									
Хүчирхийлэл	X85-Y09	13780	17284	18438	18769	19657	87928	8.8	
Амиа хорлох	X60-X84	1271	1392	1281	1461	1712	7117	0.7	


2025 оны байдлаар 25740 хүн осолд өртөх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байсан бөгөөд энэ нь өмнөх оноос 19%-иар өссөн үзүүлэлттэй байна. Мөн 10 000 хүн амд ногдох тохиолдлын түвшин 75.3 тохиолдол байна.

Осолд өртөх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байсан тохиолдол



2025 онд бүртгэгдсэн нийт тохиолдлын таван хүн тутмын нэг нь толгойн гэмтэлд өртөж байна. Эдгээр тэргүүлэх 5 байршил нь нийт тохиолдлын 69.5%-ийг бүрдүүлж байгаа ба осол гэмтлийн ихэнх нь толгой болон дээд, доод мөчдийн хэсэгт төвлөрч байна.

ГЭМТЛИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 БАЙРШИЛ



Толгой, мөчдийн гэмтэл зонхилж байгаа нь уналт, зам тээврийн осол болон механик хүчинд өртөх шалтгаануудтай уялдаж байна.

Гэмтлийн байршил	n=232315	%
Толгойн гэмтэл	48560	20.9
Бугуй ба сарвууны гэмтэл	31349	13.5
Шагай ба тавхайн гэмтэл	29696	12.8
Тохой ба шууны гэмтэл	27107	11.7
Өвдөг ба шилбэний гэмтэл	24649	10.6

Цээжний гэмтэл	13100	5.6
Мөр бабугалганы гэмтэл	12165	5.2
Хэвлийн гэмтэл	12061	5.2
Түлэгдэлт	7626	3.3
Түнх ба гуяны гэмтэл	7290	3.1
Эмийн бус хордлого	4508	1.9
Хүзүүний гэмтэл	1960	0.8
Бусад тодорхойгүй хэсгийн гэмтэл	7555	3.3
Биеийн сүвээр орсон гадны биет	1482	0.6
Бусад тодорхойгүй нөлөөлөл	1243	0.5
Биеийн олон хэсгийн гэмтэл	337	0.1
Хөлдөлт	453	0.2
Эм бэлдмэлийн хордлого	648	0.3
Хүндрэл	526	0.2


2025 оны осол гэмтлийн өвчлөлийн шалтгааныг насны бүлгээр авч үзэхэд бүх насны бүлэгт уналтын шалтгаан тэргүүлэх байр суурийг эзэлж харин амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөл нийт насны бүлэгт 2-р байрт бүртгэгдсэн байна. Түлэгдэлтийн шалтгаан нь 0–4 насны бүлэгт 3-рт, 5–9 насны бүлэгт 5-р байрт тус тус эрэмбэлэгдсэн нь бага насны хүүхдүүдийн дунд түлэгдэлтийн эрсдэл өндөр хэвээр байгааг илтгэж байна. Бусад насны бүлгүүдэд зам тээврийн осол, амьтай механик хүчинд өртөх, түүнчлэн хүчирхийллийн шалтгаант гэмтэл зонхилон бүртгэгдэж байгаа нь нас ахихын хэрээр гадаад орчны болон нийгмийн эрсдэлт хүчин зүйлсийн нөлөө нэмэгдэж байгааг харуулж байна.

Насны бүлэг	ОСОЛ ГЭМТЛИЙН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН				
	I	II	III	IV	V
0-4 (n=21436)	Уналт 41.5%	Амьгүй механик хүчинд өртөх 19.1%	Түлэгдэлт 15.3%	Амьтай механик хүчинд өртөх 14.4%	Зам тээврийн осол 3.7%
5-9 (n=19017)	Уналт 47.9%	Амьгүй механик хүчинд өртөх 19.8%	Амьтай механик хүчинд өртөх 13.1%	Зам тээврийн осол 11.3%	Түлэгдэлт 3.6%
10-14 (n=27317)	Уналт 44.6%	Амьгүй механик хүчинд өртөх 19.5%	Зам тээврийн осол 14.7%	Амьтай механик хүчинд өртөх 13.9%	Хүчирхийлэл 3.7%
15-19 (n=23486)	Уналт 37.3%	Амьгүй механик хүчинд өртөх 20.8%	Зам тээврийн осол 18.3%	Амьтай механик хүчинд өртөх 11.9%	Хүчирхийлэл 6.8%
20-24 (n=16794)	Уналт 30.3%	Амьгүй механик хүчинд өртөх 22.6%	Зам тээврийн осол 17.7%	Хүчирхийлэл 13.9%	Амьтай механик хүчинд өртөх 8.1%
25-29 (n=16530)	Уналт 30.9%	Амьгүй механик хүчинд өртөх 22.1%	Зам тээврийн осол 15.9%	Хүчирхийлэл 15.6%	Амьтай механик хүчинд өртөх 7.3%
30-34 (n=17940)	Уналт 31.8%	Амьгүй механик хүчинд өртөх 21.8%	Хүчирхийлэл 16.1%	Зам тээврийн осол 14.3%	Амьтай механик хүчинд өртөх 6.3%
35-39 (n=19787)	Уналт 33.1%	Амьгүй механик хүчинд өртөх 20.8%	Хүчирхийлэл 15.5%	Зам тээврийн осол 13.9%	Амьтай механик хүчинд өртөх 5.5%
40-44 (n=15550)	Уналт 34.0%	Амьгүй механик хүчинд өртөх 20.8%	Зам тээврийн осол 13.7%	Хүчирхийлэл 13.1%	Амьтай механик хүчинд өртөх 5.3%
45-49 (n=13107)	Уналт 37.3%	Амьгүй механик хүчинд өртөх 19.2%	Зам тээврийн осол 14.1%	Хүчирхийлэл 11.4%	Амьтай механик хүчинд өртөх 5.5%


50-54 (n=11604)	Уналт 42.1%	Амьгүй механик хүчинд өртөх 19.1%	Зам тээврийн осол 13.2%	Хүчирхийлэл 8.7%	Амьтай механик хүчинд өртөх 5.1%
55-59 (n=9495)	Уналт 48.1%	Амьгүй механик хүчинд өртөх 16.2%	Зам тээврийн осол 13.1%	Хүчирхийлэл 6.7%	Амьтай механик хүчинд өртөх 5.3%
60-64 (n=7716)	Уналт 52.4%	Амьгүй механик хүчинд өртөх 14.3%	Зам тээврийн осол 12.1%	Амьтай механик хүчинд өртөх 5.2%	Хүчирхийлэл 4.9%
65-69 (n=5450)	Уналт 58.1%	Амьгүй механик хүчинд өртөх 12.3%	Зам тээврийн осол 10.1%	Амьтай механик хүчинд өртөх 5.6%	Шалтгаан тодорхойгүй 2.8%
70+ (n=7086)	Уналт 70.1%	Амьгүй механик хүчинд өртөх 9.3%	Зам тээврийн осол 6.3%	Амьтай механик хүчинд өртөх 3.5%	Шалтгаан тодорхойгүй 3.5%

Осол гэмтлийн тохиолдлыг улирлаар ангилан үзэхэд зуны улиралд 64486 тохиолдол (27.8%) бүртгэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Үүний дараа хаврын улиралд 61440 тохиолдол (26.4%), намрын улиралд 57730 тохиолдол (24.8%), харин өвлийн улиралд 48659 тохиолдол (20.9%) тус тус бүртгэгдсэн байна.

Осол гэмтэлд өртсөн улирлаар, 2025 он



Осол гэмтэлд өртсөн сар, хувиар




Осол гэмтлийн тохиолдлыг сараар харахад 5-р сард 22595 тохиолдол (9.7%) бүртгэгдэж хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Үүний дараа 7-р сард 22192 (9.6%), 8-р сард 21221 (9.1%), 6-р сард 21073 (9.1%) тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Осол гэмтлийн тохиолдол хаврын сүүл болон зуны эхэн, дунд саруудад нэмэгдэх чиг хандлагатай байгаа бол өвлийн саруудад буурах хандлагатай байна. Ялангуяа 3–5 дугаар саруудад тохиолдлын тоо тогтвортой өсөж, 5-р сард дээд цэгт хүрч, улмаар намрын саруудаас аажмаар буурч байна.

Бүх улиралд уналт тэргүүлэх шалтгаан хэвээр байгаа нь осол гэмтлээс сэргийлэх бодлогын тэргүүлэх чиглэлд уналтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлэх мөн амьгүй механик хүчинд өртөх шалтгаан 2-р байранд тогтвортой байгаа нь ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах хэрэгцээтэй шаардлагатай байгааг харуулж байна. Зуны улиралд зам тээврийн ослын эзлэх хувь мэдэгдэхүйц нэмэгдэж байгаа нь улирлын хөдөлгөөний идэвхжилтэй уялдаатай байх магадлалтай гэж үзэж байна.

Гэмтсэн улирал	ОСОЛ ГЭМТЛИЙН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН				
	I	II	III	IV	V
Өвөл (n=48659)	Уналт 43.9%	Амьгүй механик хүчинд өртөх 17.9%	Хүчирхийлэл 9.7%	Зам тээврийн осол 8.3%	Амьтай механик хүчинд өртөх 8.2%
Хавар (n=61440)	Уналт 40.2%	Амьгүй механик хүчинд өртөх 19.2%	Зам тээврийн осол 12.9%	Амьтай механик хүчинд өртөх 9.5%	Хүчирхийлэл 8.5%
Зун (n=64486)	Уналт 37.1%	Амьгүй механик хүчинд өртөх 19.9%	Зам тээврийн осол 18.3%	Амьтай механик хүчинд өртөх 8.8%	Хүчирхийлэл 7.4%
Намар (n=57730)	Уналт 40.2%	Амьгүй механик хүчинд өртөх 20.8%	Зам тээврийн осол 12.3%	Амьтай механик хүчинд өртөх 8.8%	Хүчирхийлэл 8.5%

2025 онд осол гэмтэл бүртгэгдсэн харьяаллаар харвал нийслэлд нийт тохиолдлын 194664 (83.8%) нь харин орон нутагт 37651 (16.2%) нь бүртгэгдсэн байна. Аймгуудаас Дорноговь, Архангай, Өвөрхангай зэрэг аймгууд тохиолдлын тоо хамгийн өндөр байсан бол Говьсүмбэр, Ховд, Увс аймагт тохиолдол бага бүртгэгджээ.


Осол гэмтлийн шалтгаант шинэ тохиолдол, харьяаллаар 2025 он




1.1 УНАЛТЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /W00-W19/

Сүүлийн 5 жилийн байдлаар уналтын шалтгаант өвчлөл нийт осол гэмтлийн шинэ тохиолдлын 42.8 хувийг дангаараа эзэлж осол гэмтлийн тэргүүлэх шалтгаанаар бичигдэж байна. 2025 онд тухайн шалтгаанаар гэмтэж бэртсэн 93251 шинэ тохиолдол бүртгэгдсэн ба тохиолдлын түвшин 10 000 хүн амд 272.7 тохиолдол байна. 2025 онд тохиолдлын тоо өмнөх оноос 1.3 хувиар буурсан байна.

Уналтын шалтгаант өвчлөл, оноор



2025 онд уналтын шалтгаанаар бэртэж гэмтсэн тохиолдлыг хүйсээр авч үзвэл нийт тохиолдлын 51.8 хувь нь эрэгтэй, 48.2 хувь нь эмэгтэйчүүд байна.



2025 онд нэг түвшин дээр бүдэрч, тээглэж унах шалтгаан тэргүүлж дараагаар нь шат гишгүүрээс унах, мөс, цасан дээр хальтирч унах, нэг түвшнээс өөр түвшин рүү унах, тоглоомын ба спорт талбайн хэрэгслээс унаж гэмтэх шалтгаанууд тэргүүлэх 5 шалтгаанд багтсан байна.

Уналтын тэргүүлэх шалтгаан	n=93251	%
W01 Нэг түвшин дээр хальтирч, бүдэрч, тээглэж унах	52756	56.6
W10 Шатнаас унах	10360	11.1
W00 Нэг түвшин дээр цас, мөсөн дээр хальтирч унах	8831	9.5
W17 Нэг түвшнээс өөр түвшин рүү унах	4758	5.1
W09 Тоглоомын, спорт талбайн хэрэгслээс унах	3911	4.2
W06 Орноос унах	3550	3.8
W02 Тэшүүр, цана дугуйт хавтангаар гулгах үед унах	2130	2.3
W07 Сандлаас унах	2094	2.2
W03 Хүнтэй мөргөлдөх, хүн түлхэхэд унах	1405	1.5
W13 Барилга байгууламжаас унах	998	1.1
W11 Зөөврийн шат, түүнээс унах	929	1.0
W08 Бусад тавилгаас унах	577	0.6
W04 Хүнээр зөөлгүүлэх ба түшүүлэн явах үед унах	230	0.2

W18 Нэг түвшин дээр унах бусад гэмтэл	200	0.2
W19 Тодорхойгүй уналт	169	0.2
W12 Барилгын шат, түүнээс унах	154	0.2
W15 Хад, цохионоос унах	79	0.1
W05 Тахир дутуу хүний тэргэнцрээс	46	0.0
W14 Модноос унах	42	0.0
W16 Ус руу унах, живэлгүй гэмтэх	32	0.0

Уналтын шалтгаант өвчлөл нь 2025 онд 10-14 насанд тохиолдлын тоо хамгийн өндөр байна.

Уналтын шалтгаант өвчлөл, насны бүлгээр




2025 онд нийт уналтын шалтгаант осол гэмтлийн 82699 (88.7%) нь нийслэлд бүртгэгдсэн ба хаврын улиралд 24731 (26.5%) тохиолдол нь хамгийн өндөр байна.

Харьяаллаар




Улирлаар




1.2 АМЬГҮЙ МЕХАНИК ХҮЧИНД ӨРТӨХ ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /W20-W49/

Сүүлийн 5 жилийн байдлаар амьгүй механик хүчинд өртөх буюу хүний бүтээсэн эд зүйл, тоног төхөөрөмж гэх мэт аливаа амьгүй биеттэй хүрэлцэх, цохигдох, дарагдах гэх мэт шалтгааны улмаас бэртэж гэмтэх тохиолдол нийт осол гэмтлийн шинэ тохиолдлын 17.6 хувийг эзэлж, тэргүүлэх 2-р шалтгаан болсон байна. 2021-2025 онд тухайн шалтгаант осол гэмтлийн 175593 шинэ тохиолдол бүртгэгдсэн ба 2025 оны байдлаар 45490 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 11.5 хувиар өсжээ. 2025 оны байдлаар 10 000 хүн тутамд 133.0 тохиолдол байна.

Амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөл, оноор



2025 онд амьгүй механик хүчинд өртөх шалтгааны улмаас гэмтсэн тохиолдлыг хүйсээр авч үзвэл нийт тохиолдлын 65.9 хувь нь эрэгтэй, 34.1 хувь нь эмэгтэйчүүд байна.




2025 онд бусад зүйл мөргөх ба цохигдох шалтгаан тэргүүлж дараагаар нь шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохигдох, хоёр юмны хооронд хавчигдах, шахагдах шалтгаант гэмтэл, спортын хэрэгсэл мөргөх ба цохигдох, цахилгаан хөдөлгүүрт хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртсөн шалтгаанууд тэргүүлэх 5 шалтгаант багтаж байна.

Амьгүй механик хүчинд өртөх шалтгаан	n=45490	%
W22 Бусад зүйл мөргөх ба цохигдох	15808	34.8
W20 Шидэгдсэн, нурсан, унасан зүйлд цохигдох	6285	13.8
W23 Хоёр юмны хооронд хавчигдах, шахагдах	4701	10.3
W21 Спортын хэрэгсэл мөргөх ба цохигдох	3992	8.8
W29 Цахилгаан хөдөлгүүрт хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх	3347	7.4
W26 Хутганд өртөх	3124	6.9
W25 Шилэнд зүсэгдэх	2916	6.4
W27 Хөдөлгүүргүй хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өртөх	2724	6.0
W44 Нүд ба биеийн сүвээр гадны биет орох	1481	3.3
W45 Гадны биет арьсаар нэвтрэх	745	1.6
W24 Өргөх ба дамжуулах төхөөрөмж хэрэгсэлд өртөх	138	0.3
W49 Бусад ба тодорхойгүй амьгүй механик хүчинд өртөх	63	0.1

W30 Хөдөө аж ахуйн техник хэрэгсэлд өртөх	61	0.1
W37 Даралтат хийтэй машины дугуй, хоолой дэлбэрэх	27	0.1
W28 Хөдөлгүүртэй зүлэг тэгшлүүрт өртөх	16	0.0
W33 Бусад том буугаар	12	0.0
W38 Даралтат хийтэй бусад тодорхой хэрэгсэл	11	0.0
W34 Бусад тодорхойгүй галт зэвсэг	9	0.0
W31 Тодорхойгүй ба бусад машинд өртөх	6	0.0
W46 Арьсан дор тарьдаг зүүнд хатгагдах	6	0.0
W36 Хийт баллон дэлбэрэх	5	0.0
W39 Салют буудах, тэсрэх	5	0.0
W40 Бусад бодис дэлбэрэх	5	0.0


Амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөл нь 2025 онд 10-19 насанд тохиолдлын тоо хамгийн өндөр байна.

Амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөл, насны бүлгээр




2025 онд нийт амьгүй механик хүчинд өртөх шалтгаант осол гэмтлийн 38550 (84.7%) нь нийслэлд бүртгэгдэж 12892 (28.3%) тохиолдлоор зуны улиралд хамгийн өндөр байна.

Харьяаллаар




Улирлаар




1.3 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /V01-V99/

2021-2025 онд нийт 119181 зам тээврийн ослын шалтгаант шинэ тохиолдол бүртгэгдсэн ба сүүлийн оны байдлаар 30888 тохиолдол бүртгэгдэж, тухайн шалтгаант осол гэмтэл өмнөх оноос 11.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2025 онд 10 000 хүн амд ногдох тохиолдлын түвшин 90.3 тохиолдол байна.

Зам тээврийн шалтгаант осол гэмтэл, оноор



2025 онд зам тээврийн ослын улмаас осол гэмтэлд өртсөн тохиолдлыг хүйсээр харвал нийт тохиолдлын 65.5 хувь нь эрэгтэй, 34.5 хувь нь эмэгтэйчүүд байна.




2025 оны байдлаар суудлын машинтай явж байх үедээ зам тээврийн осолд орж гэмтсэн тохиолдол 9588 (31%)-р тэргүүлж, мотоциклтой зорчигч, явган зорчигч, ердийн хөсөг буюу мал амьтантай явж байсан хүн, дугуйтай зорчигчид зам тээврийн осолд өртөж гэмтсэн тохиолдлууд тэргүүлсэн хэвээр байна.

Зам тээврийн ослын шалтгаан	n=30888	%
V40-V49 Суудлын машинтай явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх	9588	31.0
V20-V39 Мотоциклтой явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх	7444	24.1
V01-V09 Явган зорчиж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх	5996	19.4
V80-V80.9 Ердийн хөсөг мал амьтан унаж явсан хүн осолд орох	3651	11.8
V10-V19 Дугуйтай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх	3321	10.8

V50-V69 Ачааны машинтай хүн зам тээврийн осолд орж гэмтэх	547	1.8
V70-V79 Нийтийн тээврээр зорчиж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх	311	1.0
V81-V98 Бусад ба тодорхойгүй тээврийн хэрэгсэлтэй явж байгаад гэмтэх	30	0.1


Зам тээврийн осолд өртөгсдийг насны бүлгээр харьцуулан харахад 15-19, 10-14 насанд тохиолдлын тоо өндөр байна.

Зам тээврийн осол, насны бүлгээр





2025 онд нийт зам тээврийн ослын 22342 (72.3%) нь нийслэлд бүртгэгдэж 11789 (38.2%) тохиолдлоор зуны улиралд хамгийн өндөр байна.

Харьяаллаар



Улирлаар





II БҮЛЭГ


2025 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын
байдалд хийсэн дүн шинжилгээ

МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН БАЙДАЛ 2025 ОН

2. ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Сүүлийн 5 жилийн хугацаанд улсын хэмжээнд нийт 16063 осол гэмтлийн шалтгаант нас баралт бүртгэгдсэнээс 2025 онд 3232 тохиолдол болж өмнө оноос 3.8%-иар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 9.9 байна.

Монгол улсын гэмтлийн шалтгаант нас баралт, 10 000 хүн амд



Сүүлийн 5 жилийн байдлаар осол гэмтлийн шалтгаант нас баралтын 79.5% (12777) нь эрэгтэйчүүд байгаа бөгөөд 10 тохиолдол тутмын 8 нь эрэгтэйчүүд байна.

Хүйс	2021		2022		2023		2024		2025		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь								
Эр	2396	79.2	2721	81.2	2427	78.5	2693	80.1	2540	78.6	12777	79.5
Эм	630	20.8	632	18.8	665	21.5	667	19.9	692	21.4	3286	20.5

2025 онд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтыг насны бүлгээр 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 50-54 насанд хамгийн өндөр байна.

Насны бүлэг	2021		2022		2023		2024		2025	
	Б/Т	НБТ								
0-4	110	2.9	125	3.4	126	3.5	128	3.6	128	3.6
5-9	55	1.4	42	1.1	43	1.1	44	1.1	38	1.1
10-14	69	2.2	60	1.8	56	1.6	62	1.8	47	1.8
15-19	98	4.5	94	4.1	84	3.4	105	4.3	104	4.3
20-24	165	7.4	144	6.5	114	5.4	128	6.0	131	6.0
25-29	184	7.8	213	9.3	159	7.1	159	7.1	168	7.1
30-34	319	10.9	317	10.9	273	10.0	271	9.9	267	9.9
35-39	357	13.9	391	14.6	340	12.3	404	14.6	394	14.6
40-44	384	17.2	380	16.7	390	17.0	412	17.9	403	17.9
45-49	375	18.7	433	21.2	405	19.5	442	21.3	457	21.3
50-54	346	20.4	405	23.2	385	21.5	397	22.2	364	22.2
55-59	265	17.9	326	21.8	289	19.0	325	21.3	268	21.3
60-64	145	13.2	236	20.0	213	17.2	234	18.8	204	18.8
65-69	75	11.5	114	16.0	126	16.1	149	19.0	140	19.0
70+	79	9.2	73	8.0	89	9.2	100	10.4	119	10.4
Нийт	3026		3353		3092		3360		3232	

*БТ- Бодит тоо, *НБТ-Нас баралтын түвшин

САНААТАЙ ОСОЛ ГЭМТЭЛ

/Амиа хорлолт болон хүчирхийллийн шалтгаант осол гэмтэл/




САНАМСАРГҮЙ ОСОЛ ГЭМТЭЛ

/Уналт, зам тээврийн осол, амьгүй болон амьтай механик хүчинд өртөх, усанд живэлт, түлэгдэлт, хордолт гэх мэт/




Тодорхойгүй 4.2%

Нас баралт, хүйсээр



Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 78.6 хувийг /n=2540/ эрэгтэйчүүд, 21.4 хувийг /n=692/ эмэгтэйчүүд эзэлж байгаа ба эрэгтэйд 45-49 насанд, эмэгтэйд 35-39 насанд тохиолдлын тоо хамгийн өндөр байна.





2025 онд осол гэмтлийн шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын 57.4 хувь /n=1855/ нь согтууруулах ундаа хэрэглэсэн байна. Тэдгээрийн 82.9 хувь /n=1538/ эрэгтэйчүүд 17.1 хувийг /n=317/ эмэгтэйчүүд эзлэж байна.

Нийт нас баралтын 57.8 хувь /n=1869/ нь Улаанбаатар хотод, 42.2 хувь /n=1363/ нь хөдөө орон нутагт бүртгэгдсэн байна. Бүс, нутгаар харьцуулан үзвэл хангайн бүсэд нас баралт хамгийн өндөр байгаа бол Хөвсгөл, Төв, Сэлэнгэ аймгуудад осол гэмтлийн шалтгаант нас баралт бусад аймгуудаас өндөр бүртгэгджээ.

БҮРТГЭГДСЭН ГАЗАР	БОДИТ ТОО	ХУВЬ
Баруун бүс /n=176/		
Баян-Өлгий	31	1.0
Говь-Алтай	28	0.9
Увс	53	1.6
Ховд	39	1.2
Завхан	25	0.8
Хангайн бүс /n=513/		
Архангай	102	3.2
Баянхонгор	56	1.7
Булган	70	2.2

Хөвсгөл	133	4.1
Орхон	51	1.6
Өвөрхангай	101	3.1
Төвийн бүс /n=512/		
Дорноговь	104	3.2
Өмнөговь	53	1.6
Дундговь	36	1.1
Сэлэнгэ	124	3.8
Төв	120	3.7
Дархан-Уул	58	1.8
Говьсүмбэр	17	0.5
Зүүн бүс /n=162/		
Дорнод	87	2.7
Сүхбаатар	26	0.8
Хэнтий	49	1.5
Улаанбаатар	1869	57.8
Нийт	3232	100.0

2025 онд осол гэмтлийн шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын 14.2 хувийн 45-49 насныхан эзлэж байгаа бол хүйсээр авч үзвэл нас барсан эрэгтэйчүүд эрчүүд 45-49, эмэгтэйчүүд 35-39 насанд бусад наснаас өндөр бүртгэгдсэн байна.



2025 онд бүртгэгдсэн нийт гэмтэл хордлого, гадны шалтгааны улмаас 27 хувь /874/ буюу намрын улиралд нас баралт өндөр байна.

ОСОЛ ГЭМТЛИЙН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН

2025 оны байдлаар санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаант нас баралт тэргүүлж байгаа байна. Харин 1000 шинэ гэмтэлд ногдох үхлийн түвшинг шалтгаан тус бүрээр авч үзвэл усанд живэх, амьсгал боогдох, амиа хорлох шалтгаануудад өндөр байна.



ICD10	Шалтгаан	Нийт тохиолдол	Нас баралт	Хувь	Үхлийн түвшин
V01-V99	Зам тээврийн осол	30888	536	16.6	17.4
W00-W19	Уналт	93251	202	6.3	2.2
W20-W49	Амьгүй механик хүчинд өртөх	45490	58	1.8	1.3
W50-W64	Амьд механик хүчинд өртөх	20595	10	0.3	0.5
W65-W74	Усанд живэх	103	97	3.0	941.7
W85-X19	Түлэгдэлт	7627	57	1.8	7.5
X20-X29	Хорт амьтан ургамалд өртөх	245	1	0.0	4.1
X30-X39	Байгалийн хүчинд өртөх	811	239	7.4	294.7
X40-X49	Санамсаргүй хордох	4779	1,004	31.1	210.1
X60-X84	Амиа хорлох	1712	559	17.3	326.5
X85-Y09	Хүчирхийлэл	19657	220	6.8	11.2
Y10-Y34	Тодорхойгүй осол	4676	129	4.0	27.6
W75-W84	Амьсгал боогдох	285	114	3.5	400.0
X50-X59	Бусад	2196	6	0.2	2.7
	Нийт	232315	3232	100.0	14.1


Нас баралтын тэргүүлэх 5 шалтгааныг насны бүлгээр харвал 0-14 насанд зам тээврийн осол тэргүүлж байгаа бол 15-34 насанд амиа хорлолт, 35-70+ насанд санамсаргүй хордох шалтгаан тэргүүлж байна.

Насны бүлэг	Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 2025 он				
	I	II	III	IV	V
0-4 (n-128)	Зам тээврийн осол 18.8%	Түлэгдэлт 10.9%	Усанд живэх 9.4%	Уналт 7.0%	Санамсаргүй хордох 7.0%
5-9 (n-38)	Зам тээврийн осол 44.7%	Усанд живэх 18.4%	Санамсаргүй хордох 10.5%	Уналт 5.3%	Амьгүй механик хүчинд өртөх 5.3%
10-14 (n-47)	Зам тээврийн осол 25.5%	Амиа хорлолт 23.4%	Усанд живэх 17.0%	Санамсаргүй хордох 14.9%	Уналт 6.4%
15-19 (n-104)	Амиа хорлолт 29.8%	Зам тээврийн осол 28.8%	Уналт 11.5%	Санамсаргүй хордох 11.5%	Усанд живэх 8.7%
20-24 (n-131)	Амиа хорлолт 40.5%	Зам тээврийн осол 20.6%	Уналт 10.7%	Усанд живэх 8.4%	Санамсаргүй хорлох 6.9%
25-29 (n-168)	Амиа хорлолт 45.2%	Зам тээврийн осол 17.3%	Санамсаргүй хордох 10.1%	Уналт 6.5%	Хүчирхийлэл 6.0%
30-34 (n-267)	Амиа хорлолт 28.8%	Санамсаргүй хордох 24.0%	Зам тээврийн осол 18.4%	Хүчирхийлэл 8.2%	Уналт 5.2%
35-39 (n-394)	Санамсаргүй хордох 35.5%	Амиа хорлох 19.0%	Зам тээврийн осол 15.0%	Хүчирхийлэл 8.1%	Уналт 4.3%
40-44 (n-403)	Санамсаргүй хордох 39.7%	Амиа хорлох 17.4%	Зам тээврийн осол 15.1%	Хүчирхийлэл 6.7%	Байгалийн хүчинд өртөх 6.0%
45-49 (n-457)	Санамсаргүй хордох 35.7%	Зам тээврийн осол 16.4%	Амиа хорлох 14.9%	Хүчирхийлэл 9.4%	Байгалийн хүчинд өртөх 8.3%
50-54 (n-364)	Санамсаргүй хордох 44.0%	Зам тээврийн осол 17.0%	Амиа хорлох 9.6%	Байгалийн хүчинд өртөх 7.7%	Хүчирхийлэл 6.3%
55-59 (n-268)	Санамсаргүй хордох 36.2%	Зам тээврийн осол 16.0%	Амиа хорлох 10.4%	Байгалийн хүчинд өртөх 10.4%	Хүчирхийлэл 9.0%
60-64 (n-204)	Санамсаргүй хордох 40.7%	Байгалийн хүчинд өртөх 16.7%	Зам тээврийн осол 7.8%	Амиа хорлох 7.8%	Тодорхойгүй 7.4%
65-69 (n-140)	Санамсаргүй хордох 40.7%	Уналт 14.3%	Байгалийн хүчинд өртөх 12.1%	Зам тээврийн осол 8.6%	Амиа хорлох 5.7%
70+ (n-119)	Санамсаргүй хордох 18.5%	Уналт 17.6%	Зам тээврийн осол 16.8%	Байгалийн хүчинд өртөх 13.4%	Амиа хорлох 8.4%

2025 онд бүртгэгдсэн нийт нас баралтыг онош буюу гэмтсэн эрхтний байршлаар авч үзвэл эмийн бус бодисын хордлого /спирт, угаарын хий гэх мэт/, бусад ба тодорхойгүй нөлөөлөл /гэмтлийн шок/ болон толгойн гэмтэл тэргүүлж байна.

ICD10	Гэмтсэн эрхтний байршил	Бодит тоо	Хувь
S00-S09	Толгойн гэмтэл	518	16.0
S10-S19	Хүзүүний гэмтэл	29	0.9
S20-S29	Цээжний гэмтэл	135	4.2
S30-S39	Хэвлийн гэмтэл	58	1.8
S40-S49	Мөр ба бугалгын гэмтэл	4	0.1
S50-S59	Тохой ба шууны гэмтэл	9	0.3
S70-S79	Түнх ба гуяны гэмтэл	23	0.7
S80-S89	Өвдөг ба шилбэний гэмтэл	8	0.3
S90-S99	Шагай ба тавхай	2	0.1
T00-T09	Биеийн олон хэсгийн гэмтэл	192	5.9
T20-T32	Түлэгдэлт	46	1.4
T33-T35	Хөлдөлт	23	0.7
T10-T14	Бусад тодорхойгүй хэсгийн гэмтэл	79	2.4
T15-T19	Биеийн сүвээр орсон гадны биет	11	0.3
T36-T50	Эм бэлдмэлийн хордлого	12	0.4
T51-T65	Эмийн бус хордлого	1,006	31.1
T66-T78	Бусад тодорхойгүй нөлөөлөл	953	29.5
T79-T88	Хүндрэл	124	3.8
Нийт		3232	100.0

2025 онд нас баралт бүртгэгдсэн харьяаллаар харвал нийслэлд нийт тохиолдлын 1869 (57.8%) нь харин орон нутагт 1363 (42.2%) нь бүртгэгдсэн байна. Хөвсгөл аймагт нас баралтын тохиолдол хамгийн өндөр байна.




2.1 САНАМСАРГҮЙ ХОРДОХ, ХОРТ БОДИСТ ӨРТӨХ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /X40-X49/

2025 онд санамсаргүй хордох, хорт бодист өртсөн шалтгаант нас баралт өмнө оноос 11.9%-иар буурч, 10 000 хүн тутамд ногдох нас баралтын түвшин 2.9 болсон байна. Өөрөөр хэлбэл жилд дунджаар 1000 гаруй хүн тухайн шалтгааны улмаас амь насаа алдаж байна.

Санамсаргүй хордож нас барсан тохиолдол, 10 000 хүн амд, оноор



2025 онд санамсаргүй хордох, хорт бодист өртсөн шалтгаант нас баралтын 77.6%-ийг эрэгтэйчүүд, 22.4%-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаа буюу 10 нас баралт тутмын 7-8 нь эрэгтэй байна.




Санамсаргүй хордох хорт бодист өртөх шалтгаант нас баралтыг X45 буюу спиртэнд санамсаргүй хордох шалтгаан жил бүр тэргүүлж байна. Жишээлбэл өнгөрсөн онд 879 архины хордлогын шалтгаантай нас баралт бүртгэгдсэн буюу сард дунджаар 79 хүн амь насаа алдсан байна. Тэргүүлэх шалтгааны хоёрдугаарт X47 буюу бусад хий ууранд санамсаргүй хордох шалтгаан орж түүн дундаа угаарын хийн хордлого дийлэнх хувийг эзэлсэн байна.



Санамсаргүй хордох хорт бодист өртөх шалтгаант нас баралт 1 болон 11 сард түгээмэл тохиолдож байна.

Санамсаргүй хордож нас барсан тохиолдол, бүртгэгдсэн сараар



Санамсаргүй хордох хорт бодист өртөх шалтгаант нас баралт ихэвчлэн намар, өвлийн улирал тохиолдож байна.



■ Өвөл ■ Хавар ■ Зун ■ Намар

Гэмтэл хордлого гадны шалтгаант нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй санамсаргүй хордох хорт бодист өртөх шалтгаант нас баралтын дунджаар 36 хувь нь хөдөө орон нутагт бол 64 хувь нь нийслэл Улаанбаатар хотод бүртгэгдэж байна.




2.2 САНААТАЙГААР ӨӨРТӨӨ ГЭМТЭЛ УЧРУУЛАХ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /Х60- Х84/

Монгол улсад 2025 онд амиа хорлож нас барсан нийт 559 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 6.3%-р өссөн үзүүлэлттэй байна. Нас баралтын түвшин 2025 оныг 2021 онтой харьцуулахад 0.1 тохиолдлоор өссөн байна.

Амиа хорлож нас барсан тохиолдол, 10 000 хүн амд, оноор




Нийт тохиолдлын 85.1% нь эрэгтэйчүүд 14.9% эмэгтэйчүүд байна.



Амиа хорлож нас барах тохиолдол нь осол гэмтлийн бусад шалтгаануудаас өндөр үхлийн түвшинтэй шалтгаануудын нэг юм. Өөрөөр хэлбэл амиа хорлохыг завдсан 1000 шинэ тохиолдол тутмын 379.2-484.8 нь нас баралтаар төгссөн байна.

Амиа хорлох шалтгаант нас баралт 1000 гэмтэл тутамд



Насны бүлэг тус бүрт нас баралтын түвшингээр үзвэл он тус бүрт харилцан адилгүй байгаа ба амиа хорлож нас барсан тохиолдол 2025 онд 40-44 насанд өндөр байна.


Насны бүлэг	2021		2022		2023		2024		2025	
	Б/Т	НБТ								
0-4	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
5-9	3	0.1	2	0.1	1	0.0	1	0.0	1	0.0
10-14	17	0.5	14	0.4	11	0.3	23	0.7	11	0.7
15-19	43	2.0	37	1.6	35	1.4	35	1.4	31	1.4
20-24	59	2.7	56	2.5	48	2.3	53	2.5	53	2.5
25-29	58	2.5	83	3.6	53	2.4	68	3.0	76	2.9
30-34	73	2.5	85	2.9	72	2.6	73	2.7	77	2.8
35-39	75	2.9	68	2.5	58	2.1	86	3.1	75	2.9
40-44	42	1.9	58	2.5	72	3.1	57	2.5	70	3.0
45-49	49	2.4	46	2.3	55	2.6	46	2.2	68	2.9
50-54	33	1.9	35	2.0	36	2.0	38	2.1	35	2.0
55-59	12	0.8	29	1.9	25	1.6	21	1.4	28	1.6
60-64	10	0.9	17	1.4	15	1.2	12	1.0	16	1.1
65-69	5	0.8	6	0.8	15	1.9	6	0.8	8	0.8
70+	3	0.3	8	0.9	6	0.6	7	0.7	10	0.8
Нийт	482		544		502		526		559	

САНААТАЙГААР ӨӨРТӨӨ ГЭМТЭЛ УЧРУУЛАХ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН

Санаатайгаар өөртөө гэмтэл учруулах шалтгаант нас баралтыг Х70 буюу санаатайгаар дүүжлэх, боймлох, амьсгал боох шалтгаан жил бүр тэргүүлж байна. Тэргүүлэх шалтгааны хоёрдугаарт Х72-Х74 буюу галт зэвсэг, буугаар буудах шалтгаан орж байна.




Санаатайгаар өөртөө гэмтэл учруулах шалтгаант нас баралт ихэвчлэн хавар, зуны улирал тохиолдож байна.



Тухайн сарын ямар гаригт амиа хорлож нас барсан тохиолдол харилцан адилгүй ялгаатай байгаа бөгөөд 3,9,10 сард мягмар гараг, 1,5,6 сард баасан гараг, 2,11 сард ням гарагт тохиолдлын хувь бусад гарагуудаас өндөр байна.

Нас барсан гариг 2025 он							
Нас барсан сар	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
1 сар	20.9	9.3	11.6	11.6	34.9	0.0	11.6
2 сар	3.3	3.3	3.3	30.0	13.3	3.3	43.3
3 сар	20.7	22.4	15.5	15.5	8.6	10.3	6.9
4 сар	17.9	8.9	39.3	7.1	17.9	5.4	3.6
5 сар	15.0	13.3	5.0	13.3	30.0	20.0	3.3
6 сар	15.9	15.9	11.4	6.8	20.5	13.6	15.9
7 сар	1.9	15.4	7.7	26.9	1.9	21.2	25.0
8 сар	3.9	13.7	15.7	5.9	11.8	31.4	17.6
9 сар	13.0	57.4	3.7	7.4	7.4	5.6	5.6
10 сар	12.5	32.5	7.5	10.0	25.0	7.5	5.0
11 сар	28.9	10.5	5.3	15.8	15.8	5.3	18.4
12 сар	45.5	9.1	15.2	9.1	12.1	6.1	3.0





Санаатайгаар өөртөө гэмтэл учруулах шалтгаант нас 34.9 хувь нь хөдөө орон нутагт бол 65.1 хувь нь нийслэл Улаанбаатар хотод бүртгэгдэж байна.

2.3 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /V01-V99/


Монгол улсын хэмжээнд 2025 оны байдлаар 536 хүн зам тээврийн ослоор амь насаа алдсан бөгөөд энэ нь мөн үеэс 1.5%-р өссөн үзүүлэлттэй байна. Нас баралтын түвшин 2025 оныг 2021 онтой харьцуулахад 0.2 тохиолдлоор өссөн байна.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, 10 000 хүн амд оноор



Зам тээврийн ослоор амь насаа алдсан нийт тохиолдлын 74.4% нь эрэгтэй, 25.6% нь эмэгтэй байна. Өөрөөр хэлбэл зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан 10 хүн тутмын 7-8 нь эрэгтэйчүүд байна.

Зам тээврийн ослоор нас барсан тохиолдлын тоо 45-49 насанд хамгийн их бүртгэгдсэн байна.



ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН

Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын тэргүүлэх шалтгаанд V40-49 буюу суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх тохиолдол тэргүүлж байна. Мөн хоёрдугаарт явган зорчигч зам тээврийн осол орж гэмтэх орж байна.



Нийт зам тээврийн ослын улмаас нас барсан хүмүүсийн 74.4 хувь /399/ нь согтууруулах ундаа хэрэглэсэн байсан ба тэдгээрийн 42.9 хувь /171/ эрэгтэй, 57.1 хувь /228/ эмэгтэй байна.



4/10




6/10

Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан тохиолдлыг 2021 оныг 2025 онтой харьцуулахад суудлын машины ослын тухайн онд эзлэх хувь 14.5%-иар, бусад болон тээврийн хэрэгслийн төрөл тодорхойгүй осол 1%-иар, дугуйтай зорчигчийн осол 0.6%- иар тус тус нэмэгдсэн бол бусад тээврийн хэрэгслийн осол тодорхой хувиудаар буурсан байна.

ӨОУА-10 Код	Тээврийн хэрэгслийн төрөл	Тоо	Нас барсан он, хувиар				
			2021	2022	2023	2024	2025
V40-V49	Суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх	238	35.5	38.4	38.0	44.1	44.4
V01-V09	Явган зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх	160	26.9	23.3	27.3	25.2	29.9
V20-V39	Мотоциклтой зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх	89	23.7	24.1	19.5	18.9	16.6
V80.0-80.9	Ердийн хэсгийн осол /мориноос унах/	27	7.5	10.1	8.8	6.1	5.1
V50-V69	Ачааны машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх	17	4.3	2.6	5.2	3.6	3.2
V10-V19	Дугуйтай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх	4	0.4	0.4	0.6	1.0	0.7
V81-V99	Бусад болон тээврийн хэрэгслийн төрөл тодорхойгүй зам тээврийн осол	1	1.3	0.9	0.4	1.0	0.2
V70-V79	Автобус дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх	0	0.4	0.2	0.2	0.2	0.0
Нийт		536	100.0	100.0	100.0	100.0	100.0

Зам тээврийн ослын шалтгаант нас баралт 2020, 2022-2025 онуудад зуны улиралд хамгийн их тохиолдол бүртгэгдсэн бол 2021 оны намар нас баралт өндөр хувьтай байна.



■ Өвөл ■ Хавар ■ Зун ■ Намар



III БҮЛЭГ

Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын тандалтын мэдээ, тайлангийн үнэлгээ

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын бүртгэл, цахим мэдээний сан, мэдээ тайлантай холбоотой анхаарах зүйлс, нийтлэг алдааны тухай

3.1 Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын 2025 оны “Осол гэмтлийн тандалтын тайлан” хамгаалсан үнэлгээ

Үнэлгээний тайлбар:

2025 оны “Осол гэмтэл, гадны шалтгааны үр дагавар”-ын тайланг хүлээн авахдаа харилцагч эрүүл мэндийн байгууллагуудыг 7 үзүүлэлтээр үнэлсэн. Үүнд:

1. Цахим тайлангийн үнэлгээг Hinfo V3.0 программаас бодуулсан ЭМТ-310.1, ЭМТ- 310.2, ЭМТ-310.3 тайлангуудын бодолт сарын мэдээний нэгтгэлтэй таарч байгаа эсэхийг тулгаж үнэлсэн.
2. ЭМТ-310.1, ЭМТ-310.2, ЭМТ-310.3 тайлангуудын бодолт үнэн зөв алдаагүй, формат, тохиргоог шалгаж үнэлсэн.
3. Батлагдсан хуваарийн дагуу хугацаандаа хамгаалсан эсэхийг харгалзаж үнэлсэн.
4. Стационарын баазад өгсөн үнэлгээг өөрийн эмнэлэгт осол гэмтлийн шалтгаанаар хэвтэн эмчлүүлсэн өвчтөний мэдээллийг цахимаар илгээсэн байдлаар түүн дундаа шинэ тохиолдол осол гэмтлийн баазад бүртгэлтэй эсэхийг тулгаж үнэлсэн.
5. Сарын мэдээг сар бүрийн 5-ны дотор хугацаандаа өгсөн эсэхийг үнэлсэн.
6. Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироог үнэлэхдээ ЭМХТөв, НЭМГазарт мэдээллэж байсан осол гэмтлийн мэдээ нь тандалтын мэдээтэй таарч буй эсэхээр үнэлсэн.
7. Мэдээний сангийн алдааг Hinfo V3.0 программд “Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас” маягтын асуумж бүрээр шалгаж үнэлсэн.

Нийслэлийн эмнэлгүүдийн үнэлгээний хуудас

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Үнэлгээний төрөл							
		ЭМТ 310.1 ЭМТ 310.2 ЭМТ 310.3 маягуудаар бодогдсон тайлан сарын мэдээний нэгтгэлтэй таарсан	Тайлан зааврын дагуу үнэн, зөв бодуулсан байдал	Тайлангаа хугацаандаа өгсөн	Стационарийн бааз, логикийн зөрүүгүй	Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдал	Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироо	Мэдээний сангийн алдаа /H-info/	Дүн /%/
		15 ОНОО	8 ОНОО	10 ОНОО	10 ОНОО	12 ОНОО	15 ОНОО	30 ОНОО	100 ОНОО
1	УНТЭ	15	8	10	9	12	15	30	99%
2	УХТЭ	15	8	10	10	12	14	30	99%
3	УГТЭ	15	8	10	10	12	15	29	99%
4	ЭХЭМҮТ	15	8	10	10	12	15	29	99%
5	ГССҮТ	15	8	10	10	12	15	29	99%
6	СЭМҮТ	15	8	10	10	12	15	30	100%
7	ШШЕГ	15	8	10	10	12	14	28	97%
8	ХТС	15	8	10	10	12	15	30	100%
9	Аддиктологи	15	8	10	10	12	14	30	99%
10	ЦТЭ	15	8	10	9	12	15	30	99%
11	Энэрэл эмнэлэг	15	8	10	10	12	14	28	97%
12	ТЗНЭ	15	8	9	8	10	15	30	95%
13	ТТАХНЭ	15	8	10	10	12	15	30	100%
14	БГДЭМТ	15	8	10	10	11	14	30	98%
15	БЗДЭМТ	15	8	10	10	12	11	26	92%
16	БЗДНЭ	15	8	10	10	9	15	30	97%
17	СХДЭМТ	15	8	10	10	12	13	30	98%
18	СХДНЭ	15	8	10	9	12	15	29	98%
19	СБДЭМТ	15	8	9	10	12	15	30	99%

20	СБДНЭ	15	8	10	9	12	15	29	98%
21	ХУДЭМТ	15	8	10	10	12	15	29	99%
22	ХУДНЭ	15	8	10	9	12	15	29	98%
23	ЧДЭМТ	15	8	5	9	11	14	28	90%
24	Налайх	15	8	10	5	12	15	29	94%
25	Багануур	15	8	10	10	12	15	28	98%
26	Багахангай	15	8	10	10	8	14	30	95%
27	Жаргалант	15	8	10	10	12	15	30	100%
28	Гачуурт	15	8	10	10	12	15	29	99%
29	Хонхор	15	8	10	10	12	15	30	100%
30	Туул	15	8	10	10	12	15	30	100%
31	Мөнгөнгүүр	15	8	10	9	12	14	29	97%
32	Интермед	15	8	10	10	12	15	30	100%
33	МВГ	15	8	10	10	12	15	25	95%
34	Сонмедикал	15	8	10	10	12	15	29	99%

21 аймгийн Эрүүл мэндийн газруудын үнэлгээний хуудас

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Үнэлгээний төрөл							Дүн %/
		ЭМТ 310.1 ЭМТ 310.2 ЭМТ 502 маягтуудаар бодогдсон тайлан сарын мэдээний нэгтгэлтэй	Тайлан зааврын дагуу үнэн, зөв бодуулсан байдал	Тайлангаа хугацаандаа өгсөн	Стационарийн бааз, логикийн зөрүүгүй	Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдал	Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироо	Мэдээний сангийн алдаа	
		15 оноо	8 оноо	10 оноо	10 оноо	12 оноо	15 оноо	30 оноо	
		15	8	10	10	12	15	30	100 оноо
1	Архангай	15	8	10	10	12	15	30	100%
2	Баян-Өлгий	15	8	10	9	12	15	28	97%
3	Баянхонгор	15	8	10	9	12	15	30	99%
4	Булган	15	8	10	9	12	15	30	99%
5	Говь-Алтай	15	8	10	10	12	15	30	100%
6	Говьсүмбэр	15	8	10	10	10	15	28	97%
7	Дархан-Уул	15	8	10	9	11	15	25	93%
8	Дорноговь	15	8	10	10	12	15	30	100%
9	Дорнод	15	8	10	9	8	14	20	84%
10	Дундговь	15	8	10	10	12	15	28	98%
11	Завхан	15	8	10	10	12	15	28	98%
12	Орхон	15	8	10	9	11	15	30	98%
13	Өвөрхангай	15	8	10	10	12	15	28	98%
14	Өмнөговь	15	8	10	6	12	14	30	95%
15	Сүхбаатар	15	8	10	9	12	13	27	94%
16	Сэлэнгэ	15	8	10	9	12	15	30	99%
17	Төв	15	8	10	10	12	15	28	98%
18	Увс	15	8	10	10	12	15	28	98%
19	Ховд	15	8	10	9	10	15	25	92%
20	Хөвсгөл	15	8	10	10	7	14	28	92%
21	Хэнтий	15	8	10	8	12	15	26	94%

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын мэдээний санд сар бүр гарч буй нийтлэг алдааны тухай

ГССҮТөвийн СТСАлбаны мэргэжилтнүүд эмнэлгүүдийн осол гэмтлийн өвчлөл, нас баралтын сарын мэдээг цахимаар хүлээн авч Hinfo V3.0 программ дахь бүртгэлтэй тулган, бүртгэлийн болон логик алдаа байгаа тохиолдолд тухай бүрт нь хариу илгээдэг тул очсон и-мэйлийн дагуу мэдээний сангийн алдаагаа сар бүрдээ хянаж хэвшинэ үү!

/Тайлангийн үеэр эмнэлэг бүрт биечлэн дэлгэрэнгүй тайлбарлаж зааж өгсөн ба дараах зүйлсийг анхан шатанд үзлэг хийж, Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас буюу АМ-33 маягт хөтөлж буй эмч нартаа анхааруулна уу/

1. Регистрийн дугаар буруу орсон тохиолдолд нас, хүйс буруу бүртгэгдэх тохиолдол байна. Жишээ нь: 100-аас дээш настай хүмүүсийн ихэнх нь регистрийн дугаар буруу оруулсантай холбоотойгоор нас нь 100-р нэмэгдсэн буюу хүүхдүүд байх нь элбэг байдаг. Тиймээс 100-аас дээш настай хүмүүсийн бүртгэлээ үнэн эсэхийг нягталж хэвшинэ үү
2. 15 хүртэлх насны хүүхдүүд дунд, дээд боловсролтой болон аль нэг газар ажил эрхэлдэг гэсэн сонголт хийгдсэн байгаа эсэхийг шалгаж хэвших. Учир нь 5 настай хүүхдэд дээд боловсролтой, мөн 8 настай хүүхдэд ажил эрхэлдэг гэх мэт логикийн хувьд алдаатай бүртгэлүүд элбэг тохиолддог. Энэ нь хувь хүний мэдээллийн хэсгийг сайн шалгаагүйтэй холбоотой. Түүнчлэн хүүхэд байх үед нь бүртгэсэн мэдээллээ шинэчлээгүйтэй холбоотойгоор насанд хүрсэн хүмүүсийн албан тушаал 0-15 насны хүүхэд гэж бүртгэгдэж байна.
3. Согтууруулах ундаа хэрэглэсэн гэж мэдээлсэн тохиолдлууд дунд насанд хүрээгүй хүүхэд байгаа тохиолдолд үнэн эсэхийг заавал нягталсны дараа бүртгэх, мэдээлэх
4. Мансууруулах бодис хэрэглэсэн гэж сонгогдсон тохиолдолд заавал эргэн шалгах, лавлах
5. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед V үсэгний арын тоо нь тухайн гэмтсэн хүний ямар тээврийн хэрэгслээр явж байсныг зааж байгаа бөгөөд энэ нь арагш задарсан асуултын 1-р асуулттай таарч байх ёстой. Жишээ нь: V тэмдэглэгээний ард 1 гэсэн болон эхний асуултад унадаг дугуйг сонгоно гэсэн үг юм. Явган зорчигч бол V үсэгний ард 0 байна гэх мэт.
6. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед V үсэгний арын 2-р тоо нь тухайн гэмтсэн хүн ямар тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөнийг зааж байгаа ба энэ нь арагш задарсан асуултын 3-р асуулттай таарч байх ёстой. Жишээ нь: Суудлын машинтай явж байсан хүн шон мөргөөд түүнээсээ болж гэмтсэн бол 3 дахь асуултанд хөдөлгөөнгүй зүйл мөргөсөн гэдгийг сонгох ба V47-р кодолно.
7. Морь болон тэмээнээс унаж гэмтсэн тохиолдлыг ердийн хөсөгнөөс унасан буюу V80-р кодлох ба 2-р эгнээний асуултанд хариулахдаа жолооч, зорчигч гэх мэт сонголт огт хийхгүй. Зөвхөн уралдааны морь унаач эсвэл энгийн морь унаач гэсэн сонголтыг хийнэ.
8. Хүчирхийлэл буюу өвчний олон улсын ангиллаар дайралт, халдлага X85-Y09-өөр кодлогддог шалтгаанд биеийн болон бэлгийн бүх төрлийн санаатайгаар нэгнээ гэмтээсэн тохиолдлууд орохыг анхаарна уу. Өөрөөр хэлбэл биеэрээ болон мод, чулуу, шил, хутга гэх мэт зэвсэг ашиглан зодолдсон тохиолдлууд орно. Зарим тохиолдолд бусдад зодуулсан хүмүүсийн гэмтлийн шалтгааныг W50-аар буруу кодолсон байна. Өвчний олон улсын ангиллаар W50 нь бусад хүнд цохиулах,

- түлхүүлэх, өшиглүүлэх, мушгиулах, хазуулах, маажуулах тохиолдлууд орох ба энэ нь зөвхөн санамсаргүй гэмтээсэн тохиолдолд л сонгогдох код гэдгийг анхаарна уу. Жишээ нь: Тоглож байгаад санаандгүй нэгнээ түлхэж унагаад гэмтээсэн, сагс тоглож байгаад санаандгүй маажуулсан, гараа эргүүлж байсан хүнд санаандгүй цохигдох зэрэг нь W50 ангилалд орно. Харин санаатайгаар цохисон, маажсан, өшиглөсөн бол хүчирхийлэл гэсэн ангилалд оруулна. Мөн яг юу ашиглан зодсоныг нь тусгай тэмдэглэл хэсэгт нэмэлт тайлбар бичнэ үү!
9. Түүнчлэн хүчирхийллийг кодлохдоо хэрэглэсэн арга зүйлээс нь хамаарч ялгаатай кодолдог болохыг анхаарна уу. Жишээ нь: Санаатайгаар боосон бол X91-р, хутгалсан бол X99-р, мод чулуугаар цохисон бол Y00-р, гар хөлөөрөө цохиж зодсон бол Y04-р кодлоно.
 10. Түлэнхийн шалгаанаар /W85-X19/ тусламж авсан хүмүүст T20-T32-н хооронд онош тавих ёстой. Бүртгэгдсэн түлэнхийн тохиолдлууд дунд S-тэй оношууд байгааг анхаарна уу. Түүнчлэн яг юунд хэрхэн түлэгдсэн тухай “тусгай тэмдэглэл” багананд дэлгэрүүлэн бичнэ үү! Жишээ нь: халуун тогоотой зүйлд түлэгдсэн тохиолдлыг заавал тодруулан бичнэ.
 11. “Тусгай тэмдэглэл” хэсэгт нэмэлт тайлбар шаардлагатай тохиолдлуудыг тэмдэглэх ба тухайн мөчид юу болсоныг тусгай тэмдэглэл хэсэгт нэмэлтээр бичнэ. Ингэснээр кодолж чадахгүй байгаа болон эргэлзээтэй тохиолдлуудаа тухай бүрт нь шийдвэрлэх ач холбогдолтой.

НИЙТИЙГ ХАМАРСАН ОСОЛ ГЭМТЭЛ ГАРСАН ТОХИОЛДОЛД ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН АЛБАНД ЯАРАЛТАЙ МЭДЭЭЛЖ БАЙХЫГ АНХААРУУЛЖ БАЙНА.

Жишээ нь: Гэр бүлээрээ болон олноороо явж байгаад зам тээврийн осолд орох, ажлын байр, гэр, байшин шатаж олон хүн түлэгдэх, байгалийн гамшиг тохиолдох, барилга байшин үйлдвэр уурхай нурах гэх мэтээс болж 4 болон түүнээс олон хүн 1 дор гэмтсэн, нас барсан тохиолдлуудыг сарын мэдээний хугацааг хүлээлгүйгээр тухай бүрт gemteltandalt@gmail.com, tandalt@gemtel.moh.gov.mn хаягаар болон 88765005, 80081049, 86620105, 99021639, 88808674 дугаарт мэдээлнэ үү!

Та бүхний мэдээлж буй “Осол гэмтлийн шинэ тохиолдол” бүрийн мэдээллийн үнэн зөв, бүрэн байдал нь цаашид осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нотолгоонд суурилсан үйл ажиллагаанд хэрэглэгдэх мэдээллийн суурь болдогийг онцгой анхааран эмч мэргэжилтнүүдээ зөвлөмж арга зүйгээр ханган ажиллана уу!